



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 03 сарын 09 өдөр

Дугаар А/12

Чойр

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Монгол Улсын Батлан хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.1, Орон нутгийн хамгаалалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2.6, 8.2.7, аймгийн Засаг даргын 2021 оны 03 дугаар сарын А/73 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн хэмжээнд “Монгол цэргийн өдөр” Зэвсэгт хүчний 100 жил, Батлан хамгаалах яам үүсэн байгуулагдсаны 110 жил, Монгол хүн сансарт ниссэний 40 жилийн ойн баярыг иргэн цэргийн харилцааг бэхжүүлэх, цэргийн албаны үнэлэмжийг дээшлүүлэх, хүүхэд залуучуудад эх оронч хүмүүжил төлөвшүүлэх, аймгийн иргэдийн эрүүл мэнд, боловсролыг дэмжихэд түлхэц өгөх зорилгоор ёслол төгөлдөр тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр баталсугай.

Ажлын хэсгийн дарга:

Б.Баянмөнх (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга, дэд хурандаа)

Нарийн бичгийн дарга:

Н.Оюунбат (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын тоо бүртгэлийн офицер, ахмад)

Гишүүд:

М.Анхбаяр (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга)

С.Уранцэцэг (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга)

А.Зургаанжин (Аймгийн Боловсрол, соёл урлагийн газрын дарга)

Б.Буянтогтох (Биеийн тамир, спортын газрын дарга)

2. Ойн арга хэмжээг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, тэмцээн уралдааныг зохион байгуулж, үр дүнг танилцуулахыг ажлын хэсгийн дарга (Б.Баянмөнх)-т үүрэг болгосугай.



Б.СОДНОМ

Аймгийн Засаг даргын Тамгийн газрын  
даргын 2021 оны 03 дугаар сарын 09-ний  
өдрийн 1/12 дугаар тушаалын хавсралт



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ХЭМЖЭЭНД ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 100 ЖИЛ БАТЛАН  
ХАМГААЛАХ ЯАМ ҮҮСЭН БАЙГУУЛАГДСАНЫ 110 ЖИЛ, МОНГОЛ ХҮН САНСАРТ  
НИССЭНИЙ 100 ЖИЛИЙН ОЙГ ТЭМДЭГЛЭН ӨНГӨРҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ

| д/д | Хийж хэрэгжүүлэх ажил   | Хугацаа      | Хариуцах эзэн                                     | Тайлбар |
|-----|---|--------------|---|---------|
| 1   | Аймгийн Засаг даргын зүгээс ахмад дайчинд хүндэтгэл үзүүлэх   | III/18 нд    | Цэргийн штаб                                      |         |
|     | Ахмад дайчин Б. Зундуйг алдаршуулах ярилцлага бэлтгэн хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах                         | III/18 нд    | Цэргийн штаб,<br>Аймгийн музей                    |         |
| 2   | Аймгийн хэмжээний ЕБС-ийн дунд, ахлах ангийн сурагчдын дунд “эссэ” бичлэгийн уралдаан зохион байгуулж шалгаруулах     | III/01-18 нд | Цэргийн штаб,<br>Нийгмийн бодлогын хэлтэс         |         |
| 3   | Аймгийн хэмжээний ЕБС-ийн дунд, ахлах ангийн сурагчдын дунд “Гар зураг”-ын уралдаан зохион байгуулж, шалгаруулах      | III/01-18 нд | Цэргийн штаб,<br>Нийгмийн бодлогын хэлтэс         |         |
| 4   | Иргэдийн дунд 4 насны ангиллаар гүйлтын “кросс” уралдааныг зохион байгуулах   | III/14 нд    | Цэргийн штаб,<br>аймгийн хөнгөн атлетикийн холбоо |         |
| 5   | Аймгийн ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдын дунд “Цэрэг эх орон”-ны сэдвээр яриа танилцууллага хийх | III/16 нд    | Бэлтгэл хурандаа Д.Байгаль.                       |         |
| 6   | Аймгийн албан байгууллагуудын удирдах ажилтнуудын дунд “Хийн буудлага”-ын тэмцээн                                     | III/12 нд    | Цэргийн штаб,<br>БТСГ                             |         |

|   |  |           |   |  |
|---|--|-----------|---|--|
|   | зохион байгуулах   |           |   |  |
| 7 | Баярын хурал, шагнал гардуулах, урлаг соёлын арга хэмжээг зохион байгуулах | III/18 нд | Цэргийн штаб,<br>Төрийн захиргааны удирдлагын хэлтэс,<br>Нийгмийн бодлогын хэлтэс |  |